

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 6 дугаар
сарын 16-ны өдөр

№ 199

Улаанбаатар хот

“Банк бус санхүүгийн байгууллагаас
хаалттай өрийн бичиг гаргах журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2-т заасныг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Банк бус санхүүгийн байгууллагаас хаалттай өрийн бичиг гаргах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолоор батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллахыг өрийн бичиг гаргах Банк бус санхүүгийн байгууллагад үүрэг болгосугай.
3. Батлагдсан журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 06 дугаар
сарын 16- ны өдрийн 199 дүгээр тогтоолын хавсралт

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧИГ ГАРГАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй Банк бус санхүүгийн байгууллага /цаашид “ББСБ” гэх/ хаалттай өрийн бичгийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх /-ны зөвшөөрлийн үндсэн дээр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧИГ ГАРГАХ ББСБ-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Хаалттай өрийн бичиг гаргах ББСБ нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. Хорооноос тогтоосон дүрмийн сангийн доод хэмжээг хангасан байх;

2.1.2. Хорооноос тогтоосон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг сүүлийн 3 улирал дараалан хангаж ажилласан байх;

2.1.3. Хаалттай өрийн бичиг гаргах зөвшөөрөл хүссэн хүсэлттэй холбогдуулан Хорооноос хийсэн газар дээрх шалгалтаар хангалттай үнэлгээ авч, санхүү, төлбөрийн чадварын хувьд уг өрийн бичгийг гаргах боломжтой гэж дүгнэгдсэн;

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчлөн
найруулсан/*

2.1.4. ~~Санхүү, төлбөрийн чадварын хувьд уг өрийн бичгийг гаргах боломжтой байх;~~

*/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор хүчингүй
болгосон/*

2.1.5. Хорооноос шаардлагатай гэж үзээд тавьсан бусад шаардлага.

2.1.6. Сүүлийн жилийн тайлант хугацааны эцэст ашигтай ажилласан байх.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор нэмсэн/

2.2. ББСБ-аас гаргах хаалттай өрийн бичиг нь 12 сар хүртэлх хугацаатай байх бөгөөд Хорооноос олгосон банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дуусах хугацаанаас хэтэрч болохгүй.

2.3. Хаалттай өрийн бичиг гаргагч ББСБ болон уг өрийн бичгийг эзэмшигч талууд тухайн хаалттай өрийн бичигтэй холбоотойгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглах зэрэг аливаа хэлбэрээр нийтийг хамарсан мэдээлэл түгээж, зар сурталчилгаа явуулахыг хориглоно.

2.4. ББСБ нь хаалттай өрийн бичгийг тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны хүрээнд тухайлсан зориулалт, нөхцөл бүхий багцаар гаргаж болно.

2.5. ББСБ хаалттай өрийн бичиг гаргахыг Хороо зөвшөөрснөөрөө тухайн хаалттай өрийн бичгээс үүсэх аливаа үр дагаврыг хүлээхгүй.

2.6. ББСБ нь өөрийн хөрөнгийн 50 хувь хүртэлх хэмжээнтэй тэнцэх хэмжээний хаалттай өрийн бичиг гаргаж болно.

2.7. ББСБ нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу итгэлцлийн үйлчилгээ эрхэлдэг бол итгэлцлийн үйлчилгээ болон хаалттай өрийн бичгээр бусдаас татан төвлөрүүлсэн нийт мөнгөн хөрөнгийн хэмжээ нь өөрийн хөрөнгийн 80 хувиас хэтрэхгүй байна.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор нэмсэн/

2.8. Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ нь Монгол улсын иргэн, хуулийн этгээдээс хаалттай өрийн бичиг гаргах замаар мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлэхгүй.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор нэмсэн/

2.9. Хорооны Ажлын албаны даргын шийдвэрээр ББСБ-д хаалттай өрийн бичиг гаргахыг зөвшөөрсөн нь Хороо түүнээс үүсэх аливаа эрсдэлийг хүлээх үндэслэл болохгүй.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор нэмсэн/

ГУРАВ. ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧИГ ГАРГАХ

3.1. ББСБ нь хаалттай өрийн бичиг гаргах хүсэлтээ Хороонд ирүүлж зөвшөөрөл авахдаа дараах баримт бичгийг заавал ирүүлнэ:

3.1.1. ББСБ-ын Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл Хувь нийлүүлэгчдийн хурлаас гаргасан хаалттай өрийн бичиг гаргах тухай шийдвэрийн эх хувь;

3.1.2. ББСБ-ын хаалттай өрийн бичигтэй холбоотой зохицуулалтыг тусгаж, баталсан дүрмийн эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хувь;

3.1.3. ББСБ-ын хаалттай өрийн бичгийн зориулалт, хэлбэр, хэмжээ, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, үүсч болзошгүй эрсдлийг гэрээний талууд хэрхэн хариуцах тухай болон бусад нөхцөл, эдийн засгийн үндэслэл бүхий үр ашгийн тооцоо зэрэг мэдээллийг тусгасан танилцуулга;

3.1.4. ББСБ-аас гаргах хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээний төсөл;

3.1.5. ББСБ-ын жилийн эцсийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

3.1.6. Хорооноос шаардсан бусад баримт бичиг;

3.2. ББСБ-аас ирүүлсэн хаалттай өрийн бичиг гаргахаар ирүүлсэн хүсэлтийг холбогдох шаардлага хангасан баримт бичгийн хамт Хороо бүрэн хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 хоногийн дотор хянаж, шаардлага хангасан гэж үзвэл хаалттай өрийн бичиг гаргахыг зөвшөөрөх тухай Хорооны Ажлын албаны даргын шийдвэр гаргана.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчилсөн/

3.3. ББСБ-ын хаалттай өрийн бичиг гаргахыг зөвшөөрөх тухай шийдвэрт заасан хугацаанд тухайн хаалттай өрийн бичгийн арилжаалагдаагүй үлдэгдлийг арилжаалахыг хориглох тухай шийдвэрийг Хорооны ажлын албаны дарга гаргаж болно.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

ДӨРӨВ. ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧИГ ГАРГАХЫГ ЗӨВШӨӨРӨХӨӨС ТАТГАЛЗАХ, ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

4.1. Хорооны ажлын албаны дарга дараах үндэслэлээр ББСБ-д хаалттай өрийн бичиг гаргахыг зөвшөөрөхөөс татгалзаж энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ:

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан/

~~—4.1.1. Хороонд ирүүлсэн баримт бичиг нь агуулгын хувьд хоорондоо зөрчилтэй, төөн үзүүлэлт нь зөрүүтэй;~~

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор хүчингүй болгосон/

4.1.2. Баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл хуурамч мэдээ, баримт ашигласан нь илэрсэн;

4.1.3. Энэхүү журмын 2.1-д заасан шаардлагын аль нэгийг хангаагүй;

4.1.4. Өрийн бичиг гаргахтай холбогдуулан ББСБ нь нийтэд мэдээлэл цацаж, сурталчилгаа хийсэн.

4.1.5. холбогдох хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон.

4.2. ББСБ-ын хаалттай өрийн бичиг гаргахыг зөвшөөрөхөөс татгалзсан тохиолдолд ББСБ нь тухайн зөрчлийг бүрэн арилгасан гэж үзсэн тохиолдолд татгалзсанаас хойш 6 сараас доошгүй хугацааны дараа хүсэлтийг дахин хүлээн авч, зөвшөөрөх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/

4.3. Гаргасан хаалттай өрийн бичигтэй холбогдуулан ББСБ нь нийтэд мэдээлэл, сурталчилгаа хийсэн тохиолдолд хаалттай өрийн бичиг гаргахыг зөвшөөрсөн шийдвэрийг Хорооны Ажлын албаны дарга хүчингүй болгоно.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/

4.4. Шаардлагатай гэж үзвэл Хаалттай өрийн бичиг эзэмшигчийн гуравдагч этгээдэд хаалттай өрийн бичгээ худалдах зэргээр эзэмших эрхээ шилжүүлэхийг Хорооны Ажлын албаны даргын шийдвэрээр хязгаарлаж болно;

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/

ТАВ. ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧИГ ГАРГАГЧ ББСБ-ЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.2. Хаалттай өрийн бичиг гаргагч ББСБ дараах эрх үүрэгтэй:

5.2.1. Хорооноос тогтоосон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажиллах;

5.2.2. өрийн бичиг гаргах замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааны хүрээнд зөвхөн хаалттай өрийн бичиг гаргах танилцуулга, хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулах;

5.2.3. хаалттай өрийн бичиг худалдан авагчдад өөрийн үйл ажиллагааны талаар худал ташаа мэдээ, мэдээлэл өгөхгүй байх, хаалттай өрийн бичиг эзэмшигчийн хүсэлт, шаардлагын дагуу шаардлагатай, үнэн зөв мэдээллээр хангах;

5.2.4. олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэбсайтаар хаалттай өрийн бичиг гаргахтай холбогдуулан мэдээлэл тараах, сурталчилгаа явуулахгүй байх;

5.2.5. хаалттай өрийн бичиг эзэмшигчтэй хаалттай өрийн бичгийг худалдах, худалдан авах гэрээг байгуулж нотариатаар баталгаажуулах;

5.2.6. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу хаалттай өрийн бичиг эзэмшигчид, тэдгээрийн талаар дэлгэрэнгүй бүртгэлийг үнэн зөв хөтөлж, тайлан гаргаж улирал бүр Хороонд ирүүлж байх;

5.2.7. хаалттай өрийн бичиг эзэмшигчийн гуравдагч этгээдэд өрийн бичгийг худалдах зэргээр эзэмших эрхээ шилжүүлсэнтэй холбоотой мэдээллийг нэн даруй Хороонд ирүүлэх;

5.2.8. энэ журмын хавсралтын дагуу гаргасан “ББСБ-ын өрийн бичгийн бүртгэлийн тайлан”-г улирал бүрийн санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлэх;

5.2.9. хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

5.3. Хаалттай өрийн бичиг гаргагч ББСБ нь хаалттай өрийн бичиг эзэмшигч бүрт дараах баримт бичгээс бүрдсэн хувийн хэрэг бүрдүүлсэн байна:

5.3.1. хаалттай өрийн бичгийн танилцуулга, эдийн засгийн үндэслэл бүхий үр ашгийн тооцоо;

5.3.2. хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээ /шаардлагатай бол гэрээний хавсралт баримт бичгүүдийн хамт/;

5.3.3. хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээний дагуу хийгдсэн гүйлгээний касс, мемориалын баримтууд;

5.3.4. Хаалттай өрийн бичиг эзэмшигчийн талаарх товч мэдээлэл /анкет/;

5.3.5. Шаардлагатай бусад баримт бичиг, мэдээллүүд;

ЗУРГАА. ХААЛТТАЙ ӨРИЙН БИЧИГ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Өрийн бичиг эзэмшигч нь дараах эрх үүрэгтэй:

6.1.1. хаалттай өрийн бичгийг худалдах, худалдан авах гэрээний хугацаа дуусмагц үндсэн төлбөрийг хүүгийн хамт гэрээнд заасан дүнгээр эргүүлэн авах;

6.1.2. хаалттай өрийн бичиг гаргасан ББСБ-тай харилцан тохиролцсоны үндсэн дээр гуравдагч этгээдэд өөрийн эзэмшлийн хаалттай өрийн бичгийг худалдах зэргээр эзэмших эрхээ шилжүүлэх;

6.1.3. ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын байдлыг илэрхийлэх санхүүгийн тайлан, бусад мэдээлэлтэй танилцах;

6.1.4. хаалттай өрийн бичиг гаргах ББСБ-тай байгуулах гэрээнээс үүсч болзошгүй эрсдлийг урьдчилан тооцоолж дүгнэлт хийх;

6.1.5. хаалттай өрийн бичиг гаргахыг Хорооны Ажлын албаны даргын шийдвэрээр зөвшөөрсөн ББСБ-тай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээг байгуулж нотариатоор баталгаажуулах;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/

6.1.6. хууль тогтоомж болон хаалттай өрийн бичиг гаргагчтай байгуулсан гэрээнд заасан бусад эрх үүрэг.

ДОЛОО. ӨРИЙН БИЧИГ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

7.1. ББСБ хаалттай өрийн бичиг гаргахыг зөвшөөрсөн Хорооны Ажлын албаны даргын шийдвэрийг үндэслэн хаалттай өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээг бусад этгээдтэй бичгээр байгуулж нотариараар баталгаажуулна.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/

7.2. Өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээнд дараах зүйлийг зайлшгүй тусгасан байна:

7.2.1. ББСБ-ын нэр, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, хаяг;

7.2.2. худалдан авагч нь иргэн бол түүний овог нэр, иргэний үнэмлэхний болон регистрийн дугаар, хаяг, утас, e-мэйл хаяг;

7.2.3. худалдан авагч нь хуулийн этгээд бол түүний нэр, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, хаяг, утас, тухайн хуулийн этгээдийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны овог нэр, иргэний үнэмлэхний болон регистрийн дугаар, хаяг, утас;

7.2.4. хаалттай өрийн бичгийн зориулалт, хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хуваарь, хугацаа;

7.2.5. нэг удаагийн үйлдлээр бүрэн төлөгдөх, эсхүл хэсэгчлэн, хуваарийн дагуу төлөгдөх нөхцөл, хэлбэр;

7.2.6. хаалттай өрийн бичиг гаргах ББСБ нь хаалттай өрийн бичиг эзэмшигч өөрийн эзэмшлийн хаалттай өрийн бичгийг гуравдагч этгээдэд худалдах зэргээр эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулан тухайн гуравдагч этгээдтэй гэрээ байгуулахдаа анхны өрийн бичиг эзэмшигчтэй байгуулсан гэрээнд тусгасан зориулалт, нөхцлийг өөрчлөхгүй байх зарчмыг баримтлах;

7.2.7. өрийн бичигтэй холбоотой аливаа эрсдлийг гэрээний талууд бүрэн хариуцаж шийдвэрлэх талаар;

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 94 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон/

7.2.8. хаалттай өрийн бичиг нь өөр компаниас тусгайлан гаргасан баталгаатай эсэх;

7.2.9. хаалттай өрийн бичгийн гэрээгээр төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн авах үндэслэл, тавигдах нөхцөл, шаардлага;

7.3.10. хаалттай өрийн бичиг эзэмшигчийг холбогдох мэдээллээр хэрхэн хангах;

7.3.11. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн өрийн бичгийн хугацаа тоологдож эхлэх, гэрээний үргэлжлэх хугацаа, түүний дуусгавар болох нөхцөл.

НАЙМ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

8.1. ББСБ-аас хаалттай өрийн бичиг гарган энэхүү журмыг хэрхэн мөрдөж ажиллаж буйд Хороо хяналт тавих бөгөөд шаардлагатай гэж үзвэл ББСБ-ын үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж, ББСБ нь энэхүү журмыг зөрчсөн, цаашид үйл ажиллагаанд нь эрсдэл үүсч болзошгүй гэж үзвэл холбогдох арга хэмжээг шуурхай авна.

8.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Компанийн тухай болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

... ооОоо ...

* 1-сараар, 2- улирлаар, 3-жилээр, 4-хугацааны эцэст, 5-бусад

** 1- нэг удаа бүрэн төлөгдөх, 2- хэсэгчлэн төлөгдөх

ТАЙЛАН ХЯНАСАН:

ТАМГА ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТЭМДЭГ ЕРӨНХИЙ НЯ-БО

..... ЭДИЙН ЗАСАГЧ